

Увс аймгийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр

Иргэдийн ажиллаж амьдрах, эрүүл тохилог, аюулгүй орчинг бүрдүүлэх зорилгоор **“Орон нутгийн хөгжлийн сан”**-г иргэд олон нийтийн оролцоотойгоор төлөвлөн, төсвийн тогтвортой, ил тод, хариуцлагатай байх зарчим, хууль сахиулах албадын гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг ханган, хүний нөөцийн чадавхийг сайжруулна.

Газрыг иргэдийн оролцоотойгоор шинэчлэн зохион байгуулах, дахин төлөвлөх замаар иргэд оршин суугчдын амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө орчин үеийн шийдэлтэй барилга, хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлж, Улаангомыг улсын зэрэглэлтэй хот болгон хөгжүүлнэ.

Аймаг, сум, багийг иргэддээ нээлттэй, иргэдийн оролцоотой асуудлаа шийддэг дүрэмтэй болгох, түүний өөрөө удирдах ёсны байгууллагыг чадавхжуулах, иргэдээ сонсох нээлттэй утсыг тогтмол ажиллуулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, хариу өгөх, олон нийтийн санал асуулга явуулах, **“Иргэний танхим”**-ыг байгуулах, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, нийтийн албаны үйл ажиллагаанд хууль дээдлэх ёсыг бодитой хэрэгжүүлж, нийтийн албан хаагчдыг сонирхлын зөрчил, авлигад өртөхгүй байх, архигүй орчинг бүрдүүлж ажиллана. Энэхүү үзэл баримтлал, зарчмыг үндэслэн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулсан болно.

Нэг. "Ажилтай, орлоготой Монгол хүн "

Орон нутагт төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлж, төсвийн нээлттэй ил тод байдлыг хангах, хуулийн дагуу хяналт тавьж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгон, дэд бүтэц, үйлдвэрлэл, эрчимжсэн ХАА, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх замаар экологийн баримжаатай эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд гол зорилго оршино.

1. Орон нутагт төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэн, төсвийн нээлттэй, ил тод байдлыг хангаж, **“Шилэн халаас”** хөтөлбөр хэрэгжүүлэх, төсвийн хэлэлцүүлгийг тогтмолжуулах, аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайланг цахим шуудангаар авах нөхцөлийг бүрдүүлнэ.
2. Нэг хүнд ногдох ДНБ-ийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч, холбогдох арга хэмжээг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил жилийн зорилтод тусгаж хэрэгжүүлнэ.
3. Далд эдийн засгийг ил болгоход татварын албаны үүрэг оролцоог нэмэгдүүлэн, үйл ажиллагааг нь нээлттэй болгох, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт, сурталчилгааг сайжруулснаар татварын бааз суурийг өргөжүүлэн, татвар ногдуулалтыг бодитой төлөвлөн, хураалтыг нэмэгдүүлж, орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр жигд биелүүлж ажиллана.
4. Төрийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалт тендерийн үйл ажиллагааг цахимжуулж, олон нийтэд нээлттэй, ил тод, шударга, хүнд сурталгүй, шуурхай болгоно.
5. Орон нутгийн өмч хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, түүний хөдлөл, өөрчлөлтөнд байнга хяналт тавих, сумдад байгаа хуучин барилга объектыг ажлын байр бий болгох зориулалтаар ашиглаж болох эсэх асуудлыг судлан шийдвэрлүүлнэ.
6. Иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, дундаж давхаргыг дэмжих, иргэдийн мөнгөн хуримтлалыг өсгөх нөхцөлийг бүрдүүлэхэд банкны бодлого зорилтыг чиглүүлж ажиллана.
7. Алслагдсан бүс нутгийн иргэдийн амьжиргааны өртөг, ажилгүйдэл, ядуурлын төвшин өндөр байгааг үндэслэн, цалин, тэтгэмж тэтгэврийн нэмэгдэл, татварын хөнгөлөлт үзүүлэх, хүйтний нэмэгдэл олгох болон мах, гурилын жижиглэнгийн үнийг тогтвортой байлгах, аймагт нефтийн бүтээгдэхүүнийг шууд импортлох эрх зүйн үндэслэлийг бий болгох зэрэг асуудлаар Засгийн газарт хандаж, санал хүсэлт тавьж шийдвэрлүүлэхийн төлөө ажиллана.
8. Статистикийн мэдээллийг нээлттэй, шуурхай, олон нийтэд хүртээмжтэй болгож, шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангах, ажлын байрны нөхцөлийг сайжруулна.
9. Аймагт улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн нүүрсний зарим ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын жагсаалтанд оруулах асуудлыг холбогдох газруудад уламжлах, цемент, шохойн, тоосгоны үйлдвэр барьж ажиллуулах санаачилгыг дэмжинэ.
10. Шинээр байгуулах үйлдвэрийн байршил, зах зээлийн багтаамжийн судалгааг аймгийн төв, сумдад бүсчлэн хийлгэж, дүгнэлт гаргуулах, дотоодын нөөцдөө тулгуурлан, хөөсөнцөр хавтан, сэндвич,

хөнгөн блок, хайрга чулууны зэрэг барилгын материалын үйлдвэр, давс боловсруулах цех байгуулах, утаагүй, шахмал түлш үйлдвэрлэхийг дэмжинэ.

11. Орон нутгийн иргэдийн бүлэг нөхөрлөлийг дэмжиж, хувиараа болон бичил уурхайгаар нүүрс, алт, давс зэрэг ашигт малтмал олборлогчдын ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлж ажиллана.
12. Аймагт байгаа нүүрсний зарим орд газруудад түшиглэн, цахилгаан станц байгуулах судалгаа, техник эдийн засгийн үндэслэл хийлгэж, ажлыг эхлүүлнэ.
13. Боршоо, Шар суурь боомтын шинэчлэлийн хөтөлбөрийг үргэлжлүүлж, Боршоо боомтын шалган нэвтрүүлэх цогцолборын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх, боомтыг олон улсын статусаар ажиллуулж эхлүүлэх, орон нутагт үйлдвэрлэх түүхий эдийн нөөцгүй бараа, бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэхэд анхаарч, Боршоо дахь худалдааны төвийн барилгыг барьж дуусгана.
14. Малчин-Тэсийн 35 квт-ын 115 км, Малчин-Хар тэрмэсийн 10 квт-ын 51 км, Тэсээс Шар суурийн боомт хүртэл 10.0 квт-ын 15 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих, Тээлийн боомын арын суурин, Завхан, Баруунтуруун, Наранбулаг, Бөхмөрөн зэрэг сумын төвийн 0.4 квт-ын шугам шинэчлэх, дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлэхийг судалж шийдвэрлэнэ.
15. Дулааны станцын хоёр дахь эх үүсвэрийн барилга угсралтын ажил, шугам сүлжээний ажлыг дуусгаж, хариуцсан захиргаа, орон нутгийн өмчит аж ахуйг байгуулж ажиллуулна.
16. Аймгийн төвийн авто замын шинэчлэлийг үргэлжлүүлж, замын засвар арчлалт, Давст-Хандгайтын эхний 7,1 км замын засвар, Гашууны голын 75 урт метр гүүрний их засвар хийх, Ховдын Шивэрийн гол, Сагилын Харигийн голд модон гүүр барьж, Тэсийн голын 108 урт метр төмөр бетон гүүр барих болон Хархираа голын Ямаатын гатлаганы, Хөндлөнгийн голын гүүрний, Хяргас-Айраг нуурын хоолойд тавих бирваазны, Тэсийн Нарийний голын хуучин, шинэ гүүрийн хоорондох зам, Улаангом-Баруунтуруун чиглэлийн шороон замыг сайжруулах зураг төсөв хийлгэж, ажлыг эхлүүлнэ.
17. Тээл-Наранбулаг, Наранбулаг-Үзүүрийн булаг чиглэлийн хатуу хучилттай автозамыг барьж ашиглалтад оруулах, Улаангом-Тосонцэнгэл чиглэлийн хатуу хучилттай замыг үргэлжлүүлэн, Улаангом-Өлгий чиглэлийн автозамын зураг төсвийг бэлэн болгож, барьж эхлэнэ.
18. Аймаг, сум хоорондын авто замыг сайжруулж тэмдэгжүүлэх, хатуу хучилттай замаас Түргэн, Сагил, Давст, Тариалан, Наранбулаг сум руу салах үндсэн замыг тэмдэгжүүлж, ногоон зурвас байгуулахыг дэмжинэ.
19. Улаангом-Увс нуурын аялал жуулчлалын бааз чиглэлийн замын устай жалганд 2х2,5 м-ийн дөрвөлжин бетон хоолой тавих, Улаангомьн Бор толгойн орчныг амралт, чөлөөт цагийн бүс болгох зураг төсөв хийлгэж, Бөхмөрөний Ямаатад аялал жуулчлалын бааз байгуулах ажлыг эхлүүлнэ.
20. Аялал жуулчлалын үндсэн маршрутын дагуу байгуулах жуулчны бааз, дэн буудлуудын дэд бүтцийг бий болгох, боловсон хүчнийг бэлтгэх, сургаж дадлагажуулна.
21. Худалдааны гудамжны явган замын ажлыг үргэлжлүүлж, 2 гүүрт өргөтгөл хийх, зарим төсөвт байгууллагуудын дэргэд автомашины зогсоол барина.
22. Улаангомд цэвэр усны 2-р эх үүсвэр, цэвэр усны цагираг шугамын ажлыг үргэлжлүүлэх, Барилгын лаборатори, давтан сургалтын төвийг ашиглалтад оруулж, багаж, тоног төхөөрөмжөөр хангана.
23. Увс нуур судалгааны өртөө, Сагил сумын Харигийн гол, Тэс сумын Тэсийн голд усны харуул байгуулах, Завхан, Тэс сумдын цаг уурын өртөөнд автомат станц тавих, Тэс сумын цаг уурын өртөөний барилгыг дуусгах, Увс нуурын улсын тусгай хамгаалалттай газар, Ханхөхий, Хяргас нуурын байгалийн цогцолборт газарт байгаль хамгаалагчийн ижил загварын байр барина.
24. Мах, арьс шир боловсруулах, ноос ноолуур угаах, тэмээний ноос боловсруулах үйлдвэр, цех байгуулах санал санаачилгыг дэмжиж ажиллана.
25. Мал, махны төрөлжсөн зах, малын түүхий эд цуглуулах анхан шатны боловсруулалт хийх сүлжээ агуулахуудыг аймгийн хэмжээнд бүсчлэн байгуулна.
26. ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийлгэж, ажлыг эхлүүлнэ.
27. Нутгийн үүлдэр, омог, хэвшлийн малыг шилж сонгон, цэврээр нь үржүүлэх, сайжруулагчаар ашиглах улмаар цөм сүрэг бүрдүүлэх, малыг ээмэгжүүлэх, бүртгэлжүүлэх ажлыг үргэлжлүүлж, мэдээллийн санг баяжуулна.
28. Баруун бүсийн шилмэл хурдан морьдын даншиг наадмыг зохион байгуулах замаар хурдны удамтай морьдын угшил омгийг сайжруулан хөгжүүлэхийг дэмжинэ.

29. Түүхий эд, боловсон хүчний нөөцдөө тулгуурласан МАА-н загвар хоршоо, фермер, гахай, шувуу, зөгий үржүүлэх аж ахуй байгуулахыг дэмжиж, хоршооллын хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.
30. Сүү, сүүн бүтээгдэхүүн болон төрөл бүрийн өрхийн үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, хоршоо, нөхөрлөл, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй үнээр техник, тоног төхөөрөмж нийлүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, шинээр үйлдвэр, цех байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
31. "Увс түншлэл", "Шилмэл мал" үзэсгэлэн худалдаа, үржлийн малын үнэ хаялцуулах дуудлага худалдаа зохион байгуулж, улс, бүсийн хэмжээнд зохиогдсон арга хэмжээнд иргэн, аж ахуйн нэгжийг оролцуулах, мал сүргийн чанар, бүтцийн туршлага судлах үзүүлэх сургуулийг 1-2 суманд хийнэ.
32. Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, паразиттах өвчнийг эмчлэн сэргийлэх үйлчилгээ, арга хэмжээг чанаржуулж, мал эмнэлэг ариун цэвэр оношлогоо шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулна.
33. Газар тариалангийн бүс нутаг Улаангом, Баруунтуруун, Тариалан сумдад жишиг аж ахуй байгуулахыг дэмжиж, хамтран ажиллана.
34. Жимс, жимсгэнэ, төмс, хүнсний ногоо, үр тариалалтыг дэмжих замаар үрийн хангамж чанарыг сайжруулж, жимс, жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлийн түүхий эдийг бэлтгэх орон нутгийн сүлжээг бий болгох, хамгаалагдсан хөрсний аж ахуй эрхлэхийг дэмжиж, хүлэмжийг эрэлтэд тулгуурлан, захиалгаар нийлүүлнэ.
35. Улаангом Арсай, Түргэний Коолой, Адарганы халх, Хойд хөвөөн тариг, Баруунтурууны Зүүнтуруунд ус хуримтлуулах далан, услалтын систем барьж эхлүүлэх, зарим услалтын системийг сэргээн засварлах, хүчин чадлыг нэмэгдүүлэх зураг төсвийг хийлгэж эхлүүлэх замаар үр тариа, тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлнэ.
36. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ дахин боловсруулах үйлдвэр цех байгуулах, бүтээгдэхүүний хэмжээ, чанар, нэр төрлийг өсгөх, сав баглаа боодлыг сайжруулах, агуулах зоорь, хөргүүрийн багтаамжийг нэмэгдүүлэх иргэд, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлнэ.
37. Сумдад мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах өвс тэжээлийн нөөцийн төв байгуулах ажлыг эхлүүлэх, Өмнөговь сумын улсын нөөцийн салбарын хашаа саравчийг засварлаж, аймгийн аюулгүйн нөөцөд 1000 тн өвс, 100 тн хүчит тэжээлийн нөөц бүрдүүлнэ.
38. Бэлчээрийн менежмент, тариалангийн газар ашиглалтын бодлогыг боловсронгуй болгох, амин тэжээл бордооны хангалт, бэлчээрийн хортон шавьжтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, Ачит нуурын сав газарт аймаг дундын отрын бүс нутаг байгуулан, зохих хөрөнгө оруулалтын ажил хийлгэнэ.
39. Баруунтуруунд 10000 тонны элеватор, Хар цагаан усанд механикжсан үтрэм барихад дэмжлэг үзүүлж, Наранбулаг, Тариалан, Баруунтуруун суманд тэжээлийн үйлдвэр байгуулна.
40. Өвс хадлангийн нөөцтэй Улаангом, Баруунтуруун, Сагил, Давст, Түргэн, Бөхмөрөн, Тэс, Тариалан, Өндөрхангай сумдад механикжсан салаа байгуулах, ХАА-н болон усалгааны техник тоног төхөөрөмж, дүүжин агрегатыг захиалгаар нийлүүлэх, түүнд тохирсон засвар үйлчилгээний газар, сэлбэг хэрэгслийн техникийн зах байгуулна.
41. Улаангом зарим баг, сумын төвд дулаан тохилог, шугам сүлжээ бүхий худалдааны төв, "Хүнсний Мини зах" байгуулах ажлыг эхлүүлэх, Улаанбаатар болон бусад томоохон хотуудад Увсын брэнд бүтээгдэхүүний дэлгүүр нээж ажиллуулах санал санаачилгыг дэмжинэ.
42. Иргэдийн газар өмчлөлийг үргэлжлүүлэн шийдэж, газраа зээлд барьцаалах нөхцөлийг бүрдүүлэх, сумуудын газрын ерөнхий төлөвлөгөө хийлгэх, Улаангом инженерийн шугам сүлжээний дэвсгэр зураг, хотын болон гэр хорооллын дахин төлөвлөлтийг хэсэгчилэн хийлгэж, шинэ төлөвлөлттэй уялдуулан, газар олголтыг шийдвэрлэж байх нөхцөлийг хангана.
43. Баруунтуруун сумын агаарын тээврийн үйлчилгээг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх замаар зүүн бүсийн сумдын иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчилөх, "Дэглий цагаан" нисэх буудлын хөөрч, буух хатуу зурвасыг өргөтгөж, 50 метр болгоно.
44. Мэргэжлийн салбар холбоодын ажлыг дэмжиж, хувийн хэвшлийнхний ажлыг дүгнэх журам гаргаж хэрэгжүүлэх, тэдний эрх, үүргийн уялдааг хангуулж, хэрэглэгчдийн эрх ашгийг дээдэлж ажиллахад нь хяналт тавина.

45. Адарганы самбартай хөтөлийн орчинд ачаа тээврийн терминаль агуулахын аж ахуй байгуулахыг дэмжиж, аймгийн автовокзалыг хуучин нисэх буудлын байгууламжийг ашиглан байгуулах асуудлыг судалж шийдвэрлэнэ.
46. Дулааны станцуудын болон цахилгаан, дулаан, цэвэр бохир, хэрэглээний халуун усны шугам сүлжээнд холбогдох хэрэглэгчдийн судалгааг шинэчлэн гаргаж, холбох ажлыг зураг төсвийн дагуу үе шаттай хэрэгжүүлнэ.
47. Улаангомд шинэ орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээний зураг, төсөв хийлгэн, ажлыг эхлүүлж, цахилгаан эрчим хүчний дэд өртөө, бохир усны өргөх станц барина.
48. Улаангомдын 3-р багийн 100 хүүхдийн цэцэрлэг, 30 айлын орон сууцны барилгыг гадна шугам сүлжээнд холбоно.
49. Хотын гудамжны гэрэлтүүлгийг өргөтгөж, арын 4 замаас Чандманий хороолол хүртэлх зам дагуу гэрэлтүүлэг тавина.
50. Гашууны гол, Тэрэм хад, Адаргана, Буянт хорооллын доод хэсэг, Улиасны хэв, Барилгын хорооллын дээд хэсэг, Далангийн чиглэлд цахилгааны байнгын эх үүсвэрээр хангана.
51. 1,2-р 64, 2-р 36 айлын орон сууцны залгаа баригдсан үйлдвэрлэл үйлчилгээний газруудын нэг загварын хийцийн зураг гаргаж, жигдрүүлж шинэчлэх ажлыг зохион байгуулах, гэрэлтдэг хаягтай болгоно.
52. 1,2-р 64, 2-р 36 айлын орон сууцны өмнө байрлах гараж, зарим барилга чөлөөлөх, 2-р 36 айлын орон сууцны урд талбайд хүнсний худалдааны “Мини” зах байгуулах, 64 айлын орон сууцны урд талбайд тоглоомын талбай бүхий гаражын аж ахуй, амралт чөлөөт цагаа өнгөрөөх байгууламж, автомашины задгай зогсоол байгуулах зураг төсвийг хийж, ажлыг эхлүүлнэ.
53. ЦТП-ээр дамждаг орон сууцны дулааны шугам сүлжээг шинэчлэх зураг төсөв хийлгэж, засварын ажлыг эхлүүлнэ.
54. Суурин утас, интернет, кабелийн телевизийн гурвалсан үйлчилгээтэй шинэ технологи нэвтрүүлэх, хөдөөд гар утасны дахин дамжуулах станц нэмж суурилуулах ажлыг үргэлжлүүлэх, сумдад аймгийн телевизийн нэвтрүүлгийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлнэ.
55. Хөдөөгийн малчид, иргэдийн гар утасны дугаарыг мэдээллийн санд оруулж, онцгой шаардлагатай үед яаралтай, шуурхай мэдээлэл дамжуулах арга хэмжээг үүрэн утасны компаниудтай хамтран зохион байгуулна.
56. Сумдад ахуйн үйлчилгээний төв барих ажлыг Өндөрхангай, Зүүнхангай, Түргэнээс эхэлж, үе шаттай хэрэгжүүлэх, Өмнөговь суманд тоосгоны үйлдвэр барихыг дэмжиж, 36 айлын орон сууцны засвар, ашиглалтын асуудлыг судалж шийдвэрлэнэ.
57. Сумдын төвд нэгдсэн халаалтын сүлжээ байгуулах ажлыг Хяргас, Өмнөговь, Баруунтуруунд судалгаа, зураг төсөв хийлгэх замаар эхлүүлэх, зарим багийн төвийг цахилгаан дамжуулах агаарын шугамд холбох, нар, салхины эрчим хүчний эх үүсвэрээр хангах арга хэмжээ авна.
58. Улаангомдын үерийн даланг сэргээн засварлаж, шинээр суваг шуудуу татах замаар ногоочид, хадланчдын усан хангамжийг сайжруулж, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжинэ.
59. Хяргас, Айраг нуурын загасны нөөц тогтоох судалгаа хийлгэж, агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.
60. Бүс нутгийн хэмжээний багтаамж бүхий үйлдвэрлэлийн мэргэжилтэнг бэлтгэх чиглэлээр Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын чиглэлийг шинэчлэн тогтоож, мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог зах зээлтэй холбох, Чацаргана судлалын хүрээлэн байгуулах асуудлыг судалж шийдвэрлүүлнэ.
61. Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс байгуулан, хөдөлмөрийн бирж ажиллуулахын зэрэгцээ хувийн хөдөлмөр зуучлалыг бодлогоор дэмжин, аймаг, сумдын хөдөлмөр зуучлалын онлайн сүлжээ байгуулах, ажлын байр шинээр бий болгосон байгууллага, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх, үйлдвэрлэгчдийг зээлийн батлан даалтад хамруулна.
62. Бизнес инкубатор төвийн үйл ажиллагааг инноваци, шинэ технологи нутагшуулах, орчин үетэй нийцүүлсэн сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлж хэрэгжүүлэхэд чиглүүлнэ.
63. Сум, аж ахуйн нэгжийн захиалгаар зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжлээр мэргэжилтэнг сургаж дадлагуулах замаар жилд 1000-аас доошгүй ажлын байрыг шинээр бий болгох, ядуурлыг

бууруулах болон хөдөлмөрийн, хүнсний аюулгүй байдлын талаар баримтлах дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

64. Сумын хөгжлийн санг 100,0-500,0 сая, аймагт жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санг 3 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй болгоно.
65. Ахмадын сувиллын болон иргэдэд үйлчлэх халамжийн төвийн барилгыг ашиглалтад оруулах, асрамжийн газрын, ахмадын хорооны барилгын дээвэр, сумдын ахмадын байрыг засварлаж, Улаангомд ахмадын ордон барина.
66. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутан, ахмад настнуудыг нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих боломжийг судлан шийдвэрлүүлэх, өрхийн орлогогүй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорилтот бүлгийн судалгааг гаргаж, мэдээллийн сан бүрдүүлнэ.
67. Хатуу хучилттай замын дагуу явган хүний замын гарцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан, дэд бүтцийн стандартын дагуу засаж налуу,товруутай болгон өөрчилнө.
68. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулж, зорилтот бүлгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан, хөнгөн шуурхай хүргэх, халамжийн гэр өргөөний үйлчилгээ, оёдлын цехэд ажиллуулахыг дэмжинэ.
69. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонирхолд нийцсэн боловсрол, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг судалгаагаар эзэмшүүлэн, ажлын байраар хангаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалт, мэдээлэл, үйлчилгээний байртай болгоно.
70. Стандартчилал, хэмжил зүйн хэлтсээс аймаг, сумын ЗДТГ-уудад чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2010 олон улсын стандартыг нэвтрүүлэхэд чиглэсэн ажил явуулах, хэмжил зүйн лабораторийг зарим багаж төхөөрөмжөөр хангаж, конторын барилга шинээр барих асуудлыг судалж шийдвэрлэнэ.
71. Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, даатгуулагчдын ялангуяа малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хамрах хүрээг өргөжүүлэн, эдийн засгийн идэвхитэй хүн амд эзлэх хувийг нэмэгдүүлнэ.
72. 1990-2000 онуудад өөрөөс үл хамаарах шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг материалаа бүрдүүлсэн иргэдэд нөхөн тооцож, тэтгэвэр олгуулах ажлыг зохион байгуулна.

Дээрхи зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр 2016 онд дараахь үр дүнд хүрсэн байна.

Үүнд:

1. **Орон нутагт төсвийн эрх мэдэл нэмэгдэж, төсвийн нээлттэй, ил тод байдлыг хангасан байна.**
2. **Айл өрх бүр орлогын тодорхой эх үүсвэртэй болж, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн байна.**
3. **Татварын бааз суурь өргөжиж, төсвийн орлогын нийт зарлагад эзлэх хувь хэмжээ өссөн байна.**
4. **4000-аас доошгүй ажлын байрыг шинээр бий болгосон байна.**
5. **Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалт 30%-д хүрсэн байна.**
6. **Малын сүргийн чанарт ахиц гарч, газар тариалангийн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэн байна.**

Хоёр. Эрүүл чийрэг Монгол хүн.

Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг стандартын түвшинд хүргэж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл зан үйлийг төлөвшүүлснээр, хүүхдийн эндэгдэлийг тогтвортой бууруулж, дундаж наслалтыг уртасгана.

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаанд чиглүүлэн, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэн, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
2. Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлийн шалтгааны судалгааг хийж, эмчлэн эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллана.

3. “Эрүүл Улаангом” хөтөлбөрийг боловсруулан, эмч эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллах урамшууллын механизмыг бий болгоно.
4. Нэгдсэн эмнэлгийг дотоод цахим сүлжээнд холбон камержуулж, сувилахуйн ур чадварын кабенит, насжилт судлалын кабенитийг стандартын дагуу шинэчлэн байгуулна.
5. Өндөрхангай сум дундын эмнэлэг, Бөхмөрөн, Давст, Завхан, Зүүнхангай, Малчин, Өлгий, Сагил, Түргэн, Цагаанхайрхан сумын эрүүл мэндийн төв, Мөнхбишрэлт, Бат-үржихүй, Элбэг-өгөөж, Дунцагаан өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг стандартад нийцүүлэн өргөтгөл хийнэ.
6. Аймгийн нэгдсэн эмнэлэг, Баруунтуруун, Өмнөговь, Өндөрхангай сумын сум дундын эмнэлэг, Ховд, Хяргас, Зүүнхангай, Сагил, Бөхмөрөн, Цагаанхайрхан, Тэс сумын эрүүл мэндийн төвийн барилгад их засварыг үе шаттайгаар хийж, Зоонозын өвчин судлалын төв, Улаангомд 20 ортой эхчүүдийн амрах байр, эх хүүхдийн сувилал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төвийн барилгыг барьж ашиглалтанд оруулна.
7. Багийн эмч нарыг унаажуулан, аймгийн нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдийн алсын дуудлагын машины парк шинэчлэлийг үе шаттайгаар хийнэ.
8. Нэгдсэн эмнэлэг, Баруунтуруун, Өмнөговь, Өндөрхангай сумын сум дундын эмнэлгийг зайн оношлогооны цахим сүлжээтэй болгон, өрх сумын эрүүл мэндийн төвүүдэд гүн өрмийн худаг гаргаж, цэвэр бохир усны системд холбож, сантехникийн их засвар хийнэ.
9. Багийн эмч нарыг “Зөөврийн үзлэгийн байр”-аар хангаж, өрх сумын эрүүл мэндийн төвүүдийн дархлаажуулалтын хүйтэн хэлхээг шинэчилнэ.
10. Эрүүл мэндийн салбарын эмч мэргэжилтнүүдийг төрөлжсөн болон үндсэн мэргэжлээр гадаад дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж, эмнэлгийн тусламжийн чанар хүртээмжийг сайжруулан, сум дундын эмнэлгүүдийн тусламж үйлчилгээг өргөжүүлнэ,
11. Төв хөдөөгийн бүх эмнэлгүүдэд эмнэлгийн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх, нэн шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангаж, хатуу зөөлөн эдлэлийг үе шаттайгаар шинэчилнэ.
12. “Эрүүл мэнд-нийгмийн цогц үйлчилгээг” хөдөөгийн иргэдэд үзүүлэн, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллаж хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа шүдний өвчлөлийг бууруулна.
13. Нөхөн-Үржихүйн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж бүх сум дунд, сумын эрүүл мэндийн төвүүдийг Нөхөн-Үржихүйн эрүүл мэндийн загвар эмнэлгийн түвшинд хүргэнэ.
14. Сувилахуйн болон “Давсны хэрэглээг багасгая” аймгийн дэд хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж нэг сувилалчид ногдох өвчтөний тоог олон улсын жишигт хүргэж, өвчтөнд үйлчлэх асаргаа сувилгааны чанар хүртээмжийг дээшлүүлнэ.
15. Эрүүл мэндийн байгууллагууд, хүн олноор цуглардаг үйлчилгээний газруудад цусны даралт болон амин чухал эрхтэн тогтолцооны үзүүлэлтүүдийг хянадаг мониторууд суурилуулах асуудлыг судлан шийдвэрлэнэ.
16. Улаангомд “Уламжлалт сэргээн засах эмчилгээ”-ний, Оношлогооны төвүүдийг байгуулан, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд өдрийн эмчилгээний кабенит нээн ажиллуулна.
17. Аймгийн төвд нэгдсэн эмнэлэг, Улаангом сумын 1-р багт ортой эмнэлэг шинээр барих асуудлыг судлан шийдвэрлэж, тус багт эмийн сангийн үйлчилгээг бий болгоно.
18. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн “Эрүүл мэндийг дэмжигч” байгууллага, өрх, гэр бүлийг шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулан мөрдөж ажиллана.
19. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэн, хяналт үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгоно.
20. Аймгийн төвд 150-иас доошгүй суудалтай фитнес, нэг ээлжинд 50 хүн орох усан бассейн шинээр барьж ашиглалтанд оруулна.
21. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, иргэд чөлөөт цагаараа амрах, дасгал хөдөлгөөн хийхэд зориулагдсан биеийн тамирын ил талбай, ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулна.
22. Биеийн тамир, спортын төрлийг сум орон нутгийн онцлогт тохируулан хөгжүүлж, сумдыг бөхийн дэвжээ, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж, өсвөрийн шигшээ багийн тамирчдыг сургуулилтийн материал хэрэглэгдэхүүнээр, биеийн тамир спортын газрыг суудлын автомашинаар хангана.
23. Аймгийн “Бага олимп”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн параолимп”-ийг хоёр жил тутамд зохион байгуулж явуулна.

“Эрүүл чийрэг монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр үйлчлүүлэгчид ээлтэй, аюулгүй, тав тухтай орчин бүрдэж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж дээшилж, эхийн

эндэгдэлгүй ажиллаж байгаа амжилт тогтмолжин, 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 5 промилоор, осол гэмтлийн өвчлөл нас баралт 1-2 пунктаар буурсан байна.

Гурав.Эрдэм боловсролтой Монгол хүн

Хүүхэд бүрийн хүсэл сонирхол, авьяас чадвар хөгжих боломжийг бүрдүүлж, бие хүн, гэр бүл, нийгмийн төлөвшлийг хангана.

1.ЕБС-иуд, цэцэрлэгүүдийн анги бүрийг проектор, багш бүрийг зөөврийн компьютер, айл өрх бүрийг шатар, морин хууртай, сургуулиудыг шатрын болон байгалийн ухааны, гадаад хэлний кабинеттэй, Улаангом сумын сургуулиудыг сурагчдын автобустай болгоно.

2.Сургууль, цэцэрлэгүүдийн биеийн тамир, дуу хөгжмийн хичээлийн заалыг өргөтгөн, шинээр барьж, хэрэглэгдэхүүний хангамж, бие засах газрын нөхцлийг сайжруулан, тоог нэмэгдүүлж, утасгүй интернэтийн орчинд ажиллах боломжийг бүрдүүлнэ.

3.Орон нутгийн онцлогийг тусгасан сургалтын агуулга, арга зүй технологи бүхий аймгийн бие даасан хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

4.Хүүхэд бүр авьяасаа нээх, хөгжих боломжийг бүрдүүлэх, амжилт гаргах, мэргэжлийн чиг баримжаа олгоход үнэтэй хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн ба төрийн бус байгууллага, хамтлаг, клубын үйл ажиллагааг урамшуулах замаар тэдний оролцоонд тулгуурласан сургалтыг явуулахыг дэмжинэ.

5. Иргэд хамт олны санал, эрэлт хэрэгцээнд үндэслэн элсэлтийн шалгалтын өндөр оноо авч, багшийн мэргэжил сонгосон оюутанг гэрээгээр суралцуулах, багшийг сонгон шалгаруулах, мэргэжлээ дээшлүүлэх орчин бүрдүүлэхэд эрх зүйн болон эдийн засгийн дэмжлэг үзүүлж, багш солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

6.Нийт бичиг үсэг үл мэдэгчдээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс бусад бүх хүнийг зуун хувь бичигтэн болгож, албан бус “Гэгээрэл төв”-ийн үйл ажиллагааг өргөжүүлж “Иргэдийн насан туршийн боловсролын төв” болгон ажиллуулна.

7.“Авьяас”, “Ном” хөтөлбөрийг хэрэгжүүлж, жил бүр “Авьяас” хүүхдийн их наадам зохион байгуулан, 1000 хүүхдийн үндэсний бөхийн болон морин хуурч,бийчдийн уралдаан явуулна.

8.Багш нарын урлаг, спортын их наадмыг 2 жил тутамд зохион байгуулна

9. Аймагт “Багшийн хөгжлийн ордон”, Улаангом сумын Цогцолбор 2, мөн сумын 3-р багт сургууль цэцэрлэгийн цогцолбор, Чандмань эрдэм, ахлах 4-р сургууль, Цагаанхайрхан, Түргэн Тариалан, Зүүнговь сумдад сургуулийн барилга шинээр барьж, Улаангом сумын цогцолбор 1, 2, Чандмань-Эрдэм, Сагил, Баруунтуруун, Тэс, Зүүнхангай, Хяргас, Зүүнговь, Өмнөговь, Өлгий, Бөхмөрөн, Тариалангийн Хархираа багийн бага, Тэсийн I, II бага сургуулийн хичээлийн байрны барилгын, Улаангом сумын 3 дугаар,Ховд сумын сургуулийн сантехникийн, Улаангом сумын 250 хүүхдийн бага сургууль, цэцэрлэгийн барилгын гадна хана, таазны дулаалга, агааржуулалт, салхивчны засвар хийж, хувийн сургууль байгуулахыг дэмжинэ.

10.Малчин, Тэс, Давст, Бөхмөрөн, Зүүнговь, Тариалан, Улаангом сумын Чандмань Эрдэм, Цогцолбор 1, Ахлах 4, “Увс- Эрдэм” сургуулиудад дотуур байр шинээр барьж, Зүүнхангай, Хяргас, Зүүнговь, Тэсийн I, II бага сургууль, Өлгий, Бөхмөрөн сумын сургуулийн дотуур байрны барилгын их засвар хийнэ.

11.Тэс, Бөхмөрөн, Давст, Зүүнговь сумын сургуулиудад спортын заал шинээр барина.

12.Сагил, Өмнөговь, Зүүнговь, Тариалан сумдад тус бүр нэг, Улаангом суманд найман цэцэрлэг шинээр, Улаангом сумын 4, 6 дугаар цэцэрлэгүүдийн өргөтгөлийг барина.

13.Улаангом сумын 3 дугаар цэцэрлэгийн сантехникийн, Улаангомын 4, 5, Тэс, Өмнөговь, Өлгий, Баруунтуруун сумын цэцэрлэгийн барилгын их засвар хийж, гэр цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэн, хувийн өмчийн цэцэрлэг байгуулахыг дэмжин ажиллана.

14.Наранбулаг, Тэс, Зүүнговь, Цагаанхайрхан, Сагил, Бөхмөрөн, Малчин, Түргэн суманд соёлын төвийн шинэ барилга ашиглалтанд оруулж, Өмнөговь сумын соёлын төвийн өргөтгөл, Тариалан, Давст, Өлгий, Завхан сумын соёлын төвийн барилгад их засвар хийнэ.

15.Аймгийн хөгжилд нэн шаардлагатай нарийн мэргэжлийн боловсон хүчин гадаадад мэргэшүүлэн, Улаангом политехник коллежийг түшиглэн Шинжлэх ухаан технологийн Их сургуулийн салбарыг аймгийн стратеги зорилттой уялдуулсан мэргэжлээр байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх, 300 оюутны дотуур байрыг ашиглалтанд оруулна.

16.Баруун бүсийн газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн, иргэн, аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх замаар үр тариа, хүнсний ногооны үрийг шинэчлэх бодлого баримтлан арвин ургац бүхий сортын үр, суулгацыг турших, нутагшуулна.

17. Сумдын орон нутаг судлах танхимыг тохижуулан, соёлын өвийн хадгалалт, биет ба биет бус өвийг баримтжуулах, соёлын аялал жуулчлалын маршрут гаргаж, брэнд үзмэрийн каталогтой болох, өв тээгчдийг хойч үедээ соёлыг өвлүүлэхийг дэмжинэ.

18. Соёлын гадаад харилцааг хөгжүүлж, хамтарсан тоглолт, соёлын арга хэмжээг өргөжүүлнэ.

19. Соёл урлагийн үндэсний үйлдвэрлэл болох морин хуур, икел, сийлбэр, хувцас, гар урлалыг дэмжин хөгжүүлж, өрх бүр угийн бичиг хөтлөх ажлыг хэрэгжүүлнэ.

20. Хүүхдийн чуулганыг 2 жил тутамд, баруун бүсийн хүүхдийн чуулган, язгуур урлагийн наадмыг 2013 онд зохион байгуулна

21. Хөгжлийн бэрхшээлтэй суралцах боломжтой хүүхдийг сургууль цэцэрлэгт хамруулах, нөхөн сэргээх, саатуулах төв байгуулна.

22. Хүүхэд залуучуудын парк, хүүхдийн ордон, зуслан байгуулж, бүтэн өнчин хүүхдүүдэд дэмжлэг үзүүлж, хүүхдэд ээлтэй аймаг болно.

Сургуулийн хичээлийн байрны хүчин чадал 3810 суудлаар, дотуур байр 1075 ороор, цэцэрлэг 1125 ороор тус тус нэмэгдэж, ээлжийн коэффициент сургуульд 1,3, дотуур байр 1,0, цэцэрлэгт 1,2, нэг багшид ноогдох хүүхдийн тоог 15 болгон бууруулж, суралцагчдын тохилог орчин бүрдэж, хүүхэд бүрийн авъяас хөгжих боломжтой болно.

Дөрөв. Аюулгүй орчинтой Монгол хүн

Байгалийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хүрээлэн байгаа орчноо хамгаалах замаар ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн экологийн тэнцвэртэй аюулгүй, амар тайван орчинд ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

1. Улаангомд 500 хүний суудалтай кино театр, үзэсгэлэнгийн танхим бүхий залуучуудын “ГАЛДАН БОШИГТ” төв байгуулна.

2. Улаангом суманд 800 айлын иж бүрэн “Түмэндэлгэржав” хороолол, сумдад 200 айлын орон сууц шинээр барих зураг төсвийг хийлгэж, эхлүүлэх, Улаангом сумын багуудад загвар орон сууцны эко хороолол байгуулах ажлыг эхлүүлнэ.

3. Хүнсний аюулгүй байдлыг хангах үүднээс хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ.

4. Төв цэвэрлэх байгууламжинд өргөтгөл, шинэчлэл хийж, хими биологийн цэвэрлэгээг хийх нөхцлийг бүрдүүлнэ.

5. Ачаа, зорчигч тээврийн нэгдсэн авто вокзал байгуулна.

6. Сум, багт хүргэх шуудангийн үйлчилгээний аюулгүй, шуурхай байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

7. Дулааны 1, 2-р станцын үнсийг дахин боловсруулах, зам сайжруулахад ашиглаж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

8. Аймгийн төвд утаагүй зуух төсөл хэрэгжүүлэх, утаа багасгадаг технологийг судалж нэвтрүүлэх, Чандмань, Улиасны хэвд нүүрс, түлшний борлуулалтын цэг байгуулахыг дэмжиж, ахуйн нүүрсний үнийг тогтворжуулах, ангилан ялгах замаар нүүрсний чанарыг сайжруулахад анхаарна.

9. Хог боловсруулах үйлдвэр байгуулах, хур хогийг цэвэрлэх, хогийн цэгт биологийн нөхөн сэргээлт хийх, эмнэлэгийн аюултай хог хаягдлыг булшлах, устгах, хогны болон бохирын машин нийлүүлэх төсөл, арга хэмжээ хэрэгжүүлнэ.

10. Улаангом политехник коллежийн ойжуулагч, цэцэрлэгжүүлэгч мэргэжлийн ангийн сургалтын түшиц баазын хүрээнд Огзомын ойг нөхөн сэргээх болон Улаан Уул, Гашууны гол орчинд ногоон зурвас байгуулах төслийг дэмжиж хэрэгжүүлж ажиллана.

11. Жилд дундаар 120-оос доошгүй га-д ойжуулалт, 20-с доошгүй га-д ойн зурвас, 30-с доошгүй га-д ойн арга хэмжээ, 1000-с доошгүй га-д ойн хортонтой тэмцэх ажлыг хийж гүйцэтгэх, 10 га хүртэл газарт цэцэрлэгжүүлэлтийн ажил хийнэ.

12. Улаангомд агаарын бохирдолтыг хэмжих автомат станц байгуулна.

13. Судалгаанд үндэслэж цөлжилт хурдацтай явагдаж байгаа сум, багуудад цөлжилтийг сааруулах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх, алтны олборлолтонд тавих хяналтыг чангатгаж химийн хорт бодисын хэрэглээ, горхи булаг ширгээх, усны эхийг бохирдуулах аливаа үйлдлийг гаргуулахгүй байх арга хэмжээ авна.

14. Увс нуур -Тэсийн голын сав газрын захиргаа байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ.

15. Наранбулаг, Цагаанхайрхан, Тариалан, Түргэн сумын төвд стандартын шаардлага хангасан усан хангамжийн хүрэлцээг нэмэгдүүлэх, ундны усыг цэвэршүүлэх арга хэмжээ авна.

16. Улаангом сумын үерийн далангийн инженерийн байгууламжийг засварлаж, газар тариалангийн усан хангамжийг сайжруулах арга хэмжээ авна.

17.Усны эх үүсвэргүй, бэлчээрийн нөөц бүхий газруудад жилд дундчаар 15-с доошгүй гүн өрмийн худаг гаргах, ашиглалтгүй болсон худагийг сэргээн засварлах, геофизикийн судалгааг 50-с доошгүй цэгт хийлгэх, шар ус, хур тунадасны усыг хуримтлуулж, далан, хөв цөөрөм байгуулах, булгийг хашиж хамгаалах, ундрагыг сэргээх ажлыг зохион байгуулна.

18.Ан амьтан агнах тусгай зөвшөөрөл олголтыг оновчтой болгож, хуваарилалтыг орон нутагт шилжүүлэх нөхцөл бүрдүүлж, агнуурын менежментийг хэрэгжүүлэх, ургамлын иж бүрэн судалгаа хийж, төрөл зүйлийн нэгдсэн сантай болно.

19.Улсын тусгай хамгаалалттай газар нутагт нэмж хамруулах газрын асуудлыг судлаж, орон нутгийн тусгай хамгаалалтай газар нутгийг өргөжүүлэх, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөлүүдийг дэмжиж ажиллана.

20.ОХУ, БНХАУ-ын ШУӨЗО-ны аймгуудтай тогтоосон хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэхийн зэрэгцээ БНСУ, Япон зэрэг дэлхийн бусад өндөр хөгжилтэй орнуудтай харилцаа холбоо тогтоож гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

21.Иргэд, төрийн албан хаагчдыг гадаадын улс орнуудад мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалтад хамруулах, оюутан залуусыг их дээд сургууль, коллежид солилцон сургах нөхцөл боломжоор хангана.

22.Согтууруулах ундаа хэрэглэдэггүй эрүүл идэвхтэй амьдралын клуб байгуулах, архидалтын эсрэг үйл ажиллагаа явуулах төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

23.Аймгийн төв захын орчим болон 9, 10-р багийн нутаг дэвсгэрт “Цагдаагийн иргэдэд үйлчлэх хэсэг”-ийг ажиллуулна.

24.Улаангом сумын төв зам, гудамж талбай, авто машины зогсоол, пост болон хүн амын нягтрал, хөдөлгөөн ихтэй газруудад “Төрийн үйлчилгээний хяналтын нэгдсэн систем”-ийг суурилуулна.

25.Наранбулаг суманд “Замын цагдаагийн хяналтын хэсэг” байгуулж, шаардлагатай техник хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлнэ.

26.Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ авч, Улаангом сумын алслагдсан багуудын нутаг дэвсгэрт морьт эргүүл ажиллуулах, иргэдтэй хамтарч ажиллах нөхцөл бололцоогоор хангаж ажиллана.

27.Цагдаагийн газарт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгжийг байгуулж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд, иргэнийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

28.Үндэсий аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, үндэсий аюулгүй байдлыг хангах асуудлаар хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох журам боловсруулан ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулж, хэрэгжүүлснээр аймгийн хэмжээнд үндэсий аюулгүй байдлын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.

29.Увс аймгийн Терроризмтой тэмцэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагааны зардлыг нь жил бүр орон нутгийн төсөвт тусгуулан батлуулж, үйл ажиллагааг тогтмолжуулан идэвхижүүлнэ.

30. Төрийн нууцын хадгалалт хамгаалалт, ашиглалт, түүнд тавих хяналт шалгалтыг сайжруулж, холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдүүлнэ.

31. Хилийн малын хулгайг багасгах, хил орчмын ард иргэдийн аюулгүй орчинг хангах зорилгоор улсын хил хамгаалалтын чадавхийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авах, улсын хилийн инженерийн байгууламжийг сайжруулах зорилгоор Давст, Сагил, суманд 20 км өргөст утсан хашаа шинээр барих, Сагил, Давст сумын нутагт байрлах Сагил, Хайрхан, Давстын заставуудыг эрчим хүчний төвлөрсөн шугамд холбоход дэмжлэг үзүүлнэ.

Хүнсний аюулгүй байдал, төв суурин газрын ногоон байгууламж болон ойжуулалт, ойн зурвасын амьдралын хувь 75 хувиас доошгүй байх ба иргэд экологийн тэнцвэртэй аюулгүй, амар тайван орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Тав.Эрх чөлөөтэй Монгол хүн

Төр засгийг түмэн олондоо тунгалаг, нээлттэй байлган, хариуцлага хяналтыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгон мөрдүүлж, хүнд сурталгүй, авилгаас ангид нийтийн үйлчилгээг төлөвшүүлэн, хүн бүр хууль дээдлэн, эрх тэгш, төрөлх аймагтаа сайхан амьдрах боломжийг бүрдүүлнэ.

1.Төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй болгон, иргэд, ТББ-ын саналд тулгуурласан шийдвэр гаргах тогтолцоог бүрдүүлнэ.

2.Төрийн байгууллагууд иргэдийн санал хүсэлтэнд хуулиар тогтоосон хугацаанд хариу өгөөгүй тохиолдолд зөвшөөрсөнд тооцох зарчмыг нэвтрүүлнэ.

3. Төрийн албыг нийтийн алба болгон төлөвшүүлж, төрийн бүх шатны албан хаагчдын үүргийг тодорхой болгож, үүргийн биелэлтийг үндэслэн хариуцлага тооцдог тогтолцоонд шилжүүлнэ.
4. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэний зөвлөл, танхим, иргэдийн сэтгэл ханамжинд үндэслэн үнэлж дүгнэх зарчмыг мөрдөнө.
5. Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэн, төрийн зарим чиг үүргийг ТББ, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх ажлыг бодитойгоор хэрэгжүүлнэ.
6. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх шударга өрсөлдөөнд тулгуурласан мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.
7. Цахим Засаглал хөтөлбөрийг хэрэгжүүлэн, шилэн кабелийн ашиглалтыг сайжруулан, аймаг, сумдын төрийн байгууллагуудад мэдээлэл технологийн “Удирдлагын цогц систем” нэвтрүүлнэ.
8. Аймаг болон сумдад иргэний танхим байгуулан, хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг гаргаж, нэгдсэн цахим сүлжээнд холбон иргэдэд хуулийн зөвлөгөө үзүүлдэг мэргэжлийн хууль эрх зүйн зөвлөх үйлчилгээг бий болгоно.
9. Бөхмөрөн, Давст, Завхан, Зүүнговь, Малчин, Өлгий, Сагил, Түргэн, Ховд, Хяргас, Цагаанхайрхан сумдын ЗДТГ-г хууль эрхзүйн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллуулна.
10. Багийн иргэдэд төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор багийн бүтцийг оновчтой болгох судалгаа хийн шийдвэрлэж, багийн ИНХ-ын чадавхийг сайжруулна.
11. Төрийн үйлчилгээ төвлөрсөн хөдөөгийн зарим томоохон багуудыг жишиг баг болгон хөгжүүлэхэд бодлогоор дэмжиж, багийн төвийг шинэчлэх, засварлан тохижуулах ажлыг ээлж дараатай гүйцэтгэнэ.
12. Өлгий, Түргэн, Цагаанхайрхан, Бөхмөрөн, Зүүнхангай сумдын ЗДТГ-т автопарк шинэчлэл хийж, сумын Цагдаагийн хэсэг, багийн дарга нарыг ээлж дараатай унаажуулна.
13. Бөхмөрөн, Зүүнхангай, Тэс, Сагил, Хяргас, Завхан, Тариалан, Улаангом сумдын нутгийн захиргааны ордонг шинээр барьж, аймгийн ЗДТГ-ын барилгын өргөтгөл хийж, Өлгий, Баруунтуруун сумын ЗДТГ-ын барилгыг засварлана.
14. ШША-ны Цагдан хорих байр, ШША-ны контор, Төрийн архивын байрыг шинээр барьж, ШША-ны лабораторийг тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлнэ.
15. Бүх сумдыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс болон Улсын бүртгэлийн Ерөнхий газартай нэгдсэн сүлжээнд холбож, иргэний эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн цаасан архивыг цахимжуулж, бүртгэл мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлнэ.
16. Аймгийн ЗДТГ-т “Иргэдэд үйлчлэх нийтийн үйлчилгээний төв” байгуулах, зар мэдээллийн цахим самбар ажиллуулан иргэдийг мэдээллээр хангана.
17. Аймаг, сумын ИТХ-ын чадавхийг сайжруулж, НӨУЁБ-ын бие даасан үйл ажиллагааг бэхжүүлэн, орон нутгийн хэмжээний эрх зүйн зохицуулалтын цогц бодлоготой болно.
18. Аймгийн Эмэгтэйчүүд, Залуучуудын чуулга уулзалт зохион байгуулна.
19. Аймгийн хэмжээнд олгодог тусгай зөвшөөрлийн эрх зүйн орчинг шинэчлэх, лицензийн ашиглалтанд хяналт тавих иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
20. “Нийтийн албанд хувийн болон нийтийн ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн хэрэгжилтийг зохион байгуулан, авилга, хүнд сурталтай холбоотой мэдээллийг хүлээн авах итгэлтэй утас, и-мэйл хаяг нээж ажиллуулна.
21. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувь эзэмшил орлогыг ил тод болгож, бие даасан байдлыг дээшлүүлж, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулна.
22. Аймгийн Онцгой байдлын хэлтсийн конторын барилгад өргөтгөл, их засвар хийж, аврах, гал унтраах зориулалтын техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг үе шаттай шинэчлэхэд дэмжлэг үзүүлэн, цас зайлуулах хүнд даацын механизмаар хангана.
23. Аймгийн ОБХ-ийн эрэн хайх, аврах бүлгийн тоо чадавхийг нэмэгдүүлж аврах салбар болгон өргөтгөх, Баруунтуруун суманд Аврах гал унтраах анги байгуулах саналыг уламжлан шийдвэрлүүлнэ.
24. Зэвсэгт хүчний 0245 дугаар ангийг түшиглэн нэгдсэн сургалтын хээрийн хотхон байгуулах, 0311 дугаар ангид объектийн хамгаалалтын телекамер суурилуулж, 328 дугаар тусгай салбарт буудлагын иж бүрэн талбай байгуулах, албан хаагчдыг чийрэгжүүлэх бялдаржуулах зориулалт бүхий тренижор техник хэрэгслэлээр хангахад дэмжлэг үзүүлнэ.

Төрийн үйл ажиллагаанд иргэдээрээ хэлэлцүүлэн бодлогоо тодорхойлох, иргэдийн оролцоотой ажиллах, иргэдээрээ хянуулан, тэдний өмнө хариуцлага хүлээдэг ажил хэвшил, нийтийн үйлчилгээ ил тод, хүнд сурталгүй шуурхай болон төлөвшиж, хүний үндсэн эрх хангагдан, орон нутаг иргэдийнхээ эрх ашигт суурилан хөгжсөн байна.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх зорилтын тухай

Аймгийн ИТХ нь Шинэчлэлийн Засгийн газартай хамтран Төсвийн тухай шинэ хуулийг хэрэгжүүлэх, төрийн албыг нийтийн алба болгон өөрчлөх шинэ нөхцөлд ажиллаж байгаагаараа онцлог юм.

Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Ардчилсан намын “**Шинэ бодлого, Шинэ баг, Шинэ Увс**” хөтөлбөр, Монгол ардын намын “**Увс хүнээ дэмжиж-Увс нутгаа хөгжүүлэе**” хөтөлбөр, Монгол ардын хувьсгалт намын “**Монголоо аврах 5 хувьсгал**” хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, иргэд сонгогчид, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын санал хүсэлтүүдэд үндэслэн аймгийн эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх зорилтыг боловсрууллаа.

Оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтын төслийг 5 бүлэгт багцлан, эх үүсвэр нь баталгаажаагүй арга хэмжээг тусгахаас аль болох зайлсхийж, үндсэн гол зорилтууддаа анхаарлаа чиглүүлж, шаардагдах эх үүсвэрийн тооцоог хийж, боловсруулсныг та бүхэнд танилцуулья.

Нэг. Ажилтай, орлоготой Монгол хүн

1. Мэдээллийн технологийн орчин үеийн ололтод суурилсан цахим татварын алба болох замаар мэдээллийн урсгалыг сайжруулах
2. Татварын бааз суурийг өргөжүүлэн, татвар ногдуулалт, хураалтыг нэмэгдүүлж, сар, улирлын төлөвлөгөөг орлогын нэр төрлөөр жигд биелүүлж ажиллах
3. Төрийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалт тендерийн үйл ажиллагааг цахимжуулж, олон нийтэд нээлттэй, ил тод, шударга, хүнд сурталгүй, шуурхай болгох
4. Орон нутгийн өмч хөрөнгийн бүртгэл, хяналтыг сайжруулж, сумдад байгаа хуучин барилга объектыг ажлын байр бий болгох зориулалтаар ашиглаж болох эсэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх
5. Төсвийн хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж, орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлж, түүний нээлттэй, ил тод байдлыг хангаж, “Шилэн халаас” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх
6. Алслагдсан бүс нутгийн иргэдийн амьжиргааны өртөг, ажилгүйдэл, ядуурлын түвшин өндөр байгааг харгалзан, цалин, тэтгэмж, тэтгэврийн нэмэгдэл, татварын хөнгөлөлт үзүүлэх, хүйтний нэмэгдэл олгох болон мах, гурилын жижиглэнгийн үнийг тогтвортой байлгах, аймагт нефтийн бүтээгдэхүүнийг шууд импортлох эрх зүйн үндэслэлийг бий болгох зэрэг чиглэлээр Засгийн газарт асуудал тавих
7. Шинээр байгуулах үйлдвэрийн байршил, зах зээлийн багтаамжийн судалгааг аймгийн төв, сумдад бүсчлэн хийж, дүгнэлт гаргуулах, дотоодын нөөцдөө тулгуурлан, хайрга, чулуу, тоосгоны зэрэг барилгын материалын үйлдвэр байгуулах, шахмал түлш үйлдвэрлэхийг дэмжих
8. Орон нутагт иргэдийн бүлэг нөхөрлөлийг дэмжиж, хувиараа болон бичил уурхайгаар нүүрс, алт, давс зэрэг ашигт малтмал олборлогчдын ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлж ажиллах
9. Боршоо боомтын шалган нэвтрүүлэх цогцолборын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх, Боршоо дахь худалдааны төвийн барилгыг барьж дуусгах
10. Малчин-Тэсийн, Малчин-Хар тэрмисийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын ажлыг дуусгах
11. Дулааны станцын хоёр дахь эх үүсвэрийн барилга угсралтын ажил, шугам сүлжээний ажлыг дуусгаж, хариуцсан захиргаа, орон нутгийн өмчит аж ахуйг байгуулж ажиллуулах
12. Дулааны станцуудын болон цахилгаан, дулаан, цэвэр, бохир, хэрэглээний халуун усны шугам сүлжээнд холбогдох хэрэглэгчдийн судалгаа шинэчлэн гаргаж, дулаан дамжуулах төвүүдээс эхний ээлжинд холбох ажлыг зураг төсвийн дагуу үе шаттай хэрэгжүүлж эхлэх
13. Улаангомын зарим багийн нутагт газар төлөвлөлтийг дахин хийлгэх, нийтийн тээврийн зориулалтын автобусаар хангаж, үйлчилгээнд гаргах
14. Улаангом сумын 3-р багт баригдсан 100 хүүхдийн цэцэрлэг, Орон сууц хөтөлбөрийн 30 айлын орон сууцыг гадна инженерийн шугам сүлжээнд холбох
15. Гашууны гол, Тэрэм хад, Адаргана, Буянт хорооллын доод хэсэг, Улиасны хэв, Барилгын хорооллын дээд хэсэг, Далангийн чиглэлд цахилгааны байнгын эх үүсвэрээр хангах
16. 1,2-р 64, 2-р 36 айлын орон сууцны өмнө байрлах гараж, зарим барилга чөлөөлөх, 2-р 36 айлын орон сууцны урд талбайд хүнсний худалдааны “Мини” зах байгуулах
17. 64 айлын орон сууцны урд гаражийн аж ахуй, тоглоомын талбай, амралт чөлөөт цагаа өнгөрөөх байгууламж, автомашины задгай зогсоолын иж бүрэн зураг төсөв хийх

18. Аймгийн төвийн авто замын шинэчлэл, гэрэлтүүлгийн ажлыг үргэлжлүүлэх, Давст-Хандгайтын эхний 7,1 км замын засвар, Гашууны голын 75 урт метр гүүрний их засвар хийх, Ховдын Шивэрийн гол, Сагилын Харигийн голд модон гүүр барьж, Тэсийн голын 108 урт метр төмөр бетон гүүрийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх
19. Тээл-Наранбулаг, Наранбулаг-Үзүүрийн булаг чиглэлийн хатуу хучилттай автозамыг барьж ашиглалтад оруулах, Улаангом-Өлгий чиглэлийн автозамын зураг төсвийг бэлэн болгох, барилга угсралтын ажлыг эхлүүлэх
20. Улаангом-Увс нуурын аялал жуулчлалын бааз чиглэлийн замын устай жалганд 2х2,5м-ийн дөрвөлжин хоолой тавих, Улаангом-Бор толгойн орчныг амралт, чөлөөт цагийн бүс болгох зураг төсөв хийлгэх
21. Худалдааны гудамжны явган замын ажлыг үргэлжлүүлж, 2 гүүрт өргөтгөл хийх, зарим төсөвт байгууллагуудын дэргэд автомашины зогсоол хийх
22. Улаангомд цэвэр усны 2-р эх үүсвэр, цэвэр усны цагираг шугамын ажлыг үргэлжлүүлж, Барилгын лаборатори, давтан сургалтын төвийг ашиглалтад оруулах
23. Аймгийн автовокзалын болон Өмнөговь сумын 36 айлын орон сууцны асуудлыг холбогдох яаманд тавьж шийдвэрлүүлэх
24. Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн, бизнес аялал зохион байгуулах, үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гаргах
25. Түргэн, Зүүнхангай, Өндөрхангай сумдад ахуйн үйлчилгээний төв барих
26. Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах, аймгийн аюулгүйн нөөцөд 1000 тн өвс, 100 тн хүчит тэжээл бэлтгэх, Өмнөговь сум дахь улсын нөөцийн салбарын склад, саравчийг засварлах,
27. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1945,0 мянган толгой мал, паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 700,0 мянган толгой мал, бруцеллёз өвчнөөс эрүүлжүүлэх шинжилгээнд 20,0 мянган толгой малыг хамруулж, мал сүрэгт ангилалт, ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлт хийх ажлыг үргэлжлүүлж, 30 мянган га-д бэлчээрийн хортон мэрэгч, үлийн цагаан оготны устгал хийх, 15 мянган га-д царцаатай тэмцэх арга хэмжээ авах
28. Мал, махны төрөлжсөн зах, малын түүхий эд цуглуулах анхан шатны боловсруулалт хийх сүлжээ агуулахуудыг бүсчлэн байгуулахыг дэмжих, ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах техник эдийн засгийн үзүүлэлт, зураг төсвийг хийлгэх
29. Үржлийн малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, улс, бүсийн хэмжээнд зохион байгуулагдсан арга хэмжээнд оролцох, 1500-2000 толгой үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулж, аймаг дотроо болон бусад аймгуудад сайжруулагчаар борлуулах ажлыг зохион байгуулах, мэл эмнэлэг, ариун цэвэр, оношлогоо шинжилгээний лабораторийг зарим тоног төхөөрөмжөөр хангах
30. “Ачит нуур”-ын сав газарт аймаг дундын отрын бүс нутаг байгуулан, зарим хөрөнгө оруулалтын ажлыг эхлүүлэх, Тэс суманд мал сүргийн чанар, бүтцийн туршлага судлах үзүүлэх сургуулийг зохион байгуулах
31. Бэлчээрийн зориулалттай инженерийн хийцтэй гүн өрмийн худаг 15-ыг шинээр гаргах, усан сан, хөв байгуулах судалгаа хийлгэх, Баруунтуруун сумын бэлчээрийн талбайгаас 20.0 мянган га газрыг тариалангийн талбайд шилжүүлж, эргэлтийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх
32. Аймгийн хэмжээнд 7,5 мянган га-д үр тариа, 250 га-д төмс, 185 га-д хүнсний ногоо тариалж, газар тариалангийн үйлдвэрлэлд бага, дунд оврын орчин үеийн өөрөө явагч техник, дүүжин чиргүүл, агрегат нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх
33. Улаангом-Увс нуурын даланг сэргээн засварлаж, шинээр суваг шуудуу татах
34. Увс нуурын улсын тусгай хамгаалалттай газар, Ханхөхий, Хяргас нуурын байгалийн цогцолборт газарт байгаль хамгаалагчийн нэг загварын байр барих
35. Хяргас, Айраг нуурын загасны нөөц тогтоох судалгаа хийлгэж, агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах
36. Улаангом-Увс нуурын хогны менежмент, эдийн засгийн төлөвлөгөө боловсруулах, хогны үйлдвэрийн зураг, төсөв хийлгэх
37. Сумдад аймгийн телевизийн нэвтрүүлгийг хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх, хөдөөгийн малчид, иргэдийн гар утасны дугаарыг мэдээллийн санд оруулж, онцгой шаардлагатай үед яаралтай, шуурхай мэдээлэл дамжуулах арга хэмжээг үүрэн утасны компаниудтай хамтран зохион байгуулах
38. Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс байгуулан, хөдөлмөрийн бирж ажиллуулахын зэрэгцээ хувийн хөдөлмөр зуучлалыг бодлогоор дэмжин, аймаг, сумдын хөдөлмөр зуучлалын онлайн сүлжээ байгуулах, ажлын байр шинээр бий болгосон байгууллага, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх, үйлдвэрлэгчдийг зээлийн батлан даалтад хамруулах ажлыг эхлүүлэх
39. Бизнес инкубатор төвийн үйл ажиллагааг инноваци, шинэ технологи нутагшуулах, орчин үетэй нийцүүлсэн сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлж, хэрэгжүүлэхэд чиглүүлэх

40. Сум, аж ахуйн нэгжийн захиалгаар зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжлээр мэргэжилтэнг сургаж дадлагажуулах замаар жилд 1000-аас доошгүй ажлын байрыг шинээр бий болгох, ядуурлыг бууруулах болон хүнсний аюулгүй байдлын дэд хөтөлбөр боловсруулж батлуулах
41. Ахмадын сувиллын болон иргэдэд үйлчлэх халамжийн төвийн барилгыг ашиглалтад оруулах, асрамжийн газрын болон ахмадын хорооны барилгын дээвэр, сумдын ахмадын байрыг засварлаж, Улаангомд барих ахмадын ордны зураг төсөв хийлгэх
42. Өрхийн орлогогүй ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорилтот бүлгийн судалгааг гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх
43. Хатуу хучилттай замын дагуу явган хүний замын гарцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй дэд бүтцийн стандартын дагуу засаж, налуу, товруутай болгон өөрчлөх
44. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан, зорилтот бүлгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан хөнгөн шуурхай хүргэх, халамжийн гэр өргөөний үйлчилгээ, оёдлын цех ажиллуулахыг дэмжих
45. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонирхолд нийцсэн боловсрол, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг судалгаагаар эзэмшүүлэн, ажлын байраар хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалт, мэдээлэл, үйлчилгээний байртай болгох
46. Стандартчилал, хэмжил зүйн хэлтсээс аймаг, сумын ЗДТГ-т чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2010 олон улсын стандартыг нэвтрүүлэхэд чиглэсэн ажил явуулах, хэмжил зүйн лабораторийн багаж төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх
47. 1990 – 2000 онуудад өөрөөс үл хамаарах шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох ажлыг зохион байгуулах

Хоёр. Эрүүл чийрэг Монгол хүн

Эрүүл мэндийн байгууллагад үйлчилгээний болон харилцааны соёлыг нэвтрүүлж, иргэн бүр эрүүл мэндийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй авах нөхцлийг бүрдүүлнэ.

1. Зооноз өвчин судлалын төв, Өндөрхангайн сум дундын эмнэлэгийн өргөтгөл /эмчийн 1 өрөө сууц бүхий/-ийн зураг төсөв хийлгэх
2. Зүүнхангай, Сагил, Бөхмөрөн, Цагаанхайрхан сумын эрүүл мэндийн төв, Тэс сумын эрүүл мэндийн төвийн барилгын дээврийн засвар хийх.
3. Өндөрхангай, Наранбулаг, Тариалан, Хяргас сумын эрүүл мэндийн төвүүдэд гүн өрмийн худаг гаргаж, нөхөн-үржихүйн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж сумын эрүүл мэндийн төвүүдийг “Нөхөн-үржихүйн эрүүл мэндийн” загвар эмнэлгийн түвшинд хүргэх ажлыг эхлүүлэх.
4. Нэгдсэн эмнэлгийг хяналтын камерт холбон, сувилахуйн ур чадварын кабинет, насжилт судлалын кабинетийг стандартын дагуу шинэчлэн байгуулж, хөдөөгийн багийн эмч нарыг “Зөвөрийн үзлэгийн байр” - тай болгох.
5. Эрүүл мэндийн байгууллагуудад цусны даралт болон амин чухал эрхтэн тогтолцооны үзүүлэлтүүдийг хянадаг мониторууд суурилуулж, Эрүүл мэнд-нийгмийн цогц үйлчилгээг хөдөөгийн иргэдэд үзүүлэх
6. Улаангом, хөдөөгийн сумдын айл өрхийн ариун цэврийн байгууламжинд ариутгал, халдваргүйтгэл, шавьжгүйтгэлийг хийж, иргэдийг халдварт өвчний эрсдлээс хамгаалах
7. Хүн амын дунд хорт хавдрын шалтгааныг илрүүлэх судалгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийж, үр дагаврыг нь арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх.
8. Сувилахуйн болон “Давсны хэрэглээг багасгах” дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлж эхлэх.
9. Авто тээврийн болон 0-5 хүртэлх насны хүүхдийн дундах осол гэмтлийн шалтгааныг илрүүлэх судалгаа хийж, бууруулах арга замыг тодорхойлох.
10. Нэгдсэн эмнэлгийг түшиглэн оношлогооны төв, “Хүүхдийн гэр сувилал” байгуулж, автомашины парк шинэчлэл хийх
11. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, Цусны эмч, Хэвлийн хөндийн дурангийн мэс заслын эмч, сувилагч нарыг клиникийн эмнэлгүүдэд 1 сараас доошгүй хугацаагаар мэргэшүүлэх, төрөх эмэгтэйчүүд, мэс заслын эмч, нарыг урьж ажлын байрны сургалт зохион байгуулах.
12. Улаангом, Бөхмөрөн, Өндөрхангай, Баруунтуруун сумуудад хүүхдийн амны хөндийг эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулах.
13. Өндөрхангай, Өмнөговь, Баруунтуруун сум дундын эмнэлгүүдэд “Эмнэлгийн хог хаягдлын менежмент” ийг хэрэгжүүлж, нэн шаардлагатай тоног төхөөрөмж техник хэрэгслээр ханган Улаангом сумын 1 дүгээр багт эмийн сангийн үйлчилгээ бий болгоно.

14. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн, “Эрүүл мэндийг дэмжигч” байгууллага, өрх, гэр бүлийг шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах.
15. Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлж, мөсөн гулгуурын талбай байгуулан хүүхэд залуучууд хичээллэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл бүрдүүлэх.
16. БТСГ-ыг албан хэрэгцээний зориулалтын суудлын автомашинтай болгож, өсвөрийн шигшээ багийн тамирчдын бэлтгэл, сургалт хийх хэрэглэл материалаар хангах, Улаангом суманд “Хөл бөмбөгийн загвар” талбай байгуулах.

Гурав. Эрдэм боловсролтой Монгол хүн

1. Улаангом сумын Чандмань-Эрдэм ахлах сургуулийн, 4-р цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн, Малчин сумын дотуур байрны, Өмнөговь, Сагил сумын цэцэрлэгийн барилгыг шинээр ашиглалтанд оруулж, Тариалан сумын 640 суудалтай хичээлийн байрны барилгын ажлыг үргэлжлүүлэх
2. Сурагч бүрийн авьяасыг нээж илрүүлэх, хөгжүүлэх, “Авьяас”, “Ном” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажилд амжилт гаргасан иргэд, багш, хамт олон, сум, сургууль, цэцэрлэгийг дэмжин урамшуулах, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, материаллаг орчин бүрдүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, шатарчин, даамчин анги шалгаруулах тэмцээнийг уламжлал болгон сум бүрт зохион байгуулах
3. “Багш солилцоо”-ны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ
4. Орон нутгийн онцлогийг тусгасан сургалтын агуулга, арга зүй технологи бүхий аймгийн бие даасан хөтөлбөрийг анхан шатны сургалтанд боловсруулж хэрэгжүүлнэ.
5. Тэс, Өлгий сумын цэцэрлэгийн, Баруунтуруун, Хяргас сумын сургуулийн барилгын их засвар, Бөхмөрөн сумын дунд сургуулийн дээврийн, Улаангом сумын ахлах 3 дугаар сургууль, 3 дугаар цэцэрлэгийн сантехникийн засвар, Тэс сумын ахлах сургуулийн нэгдсэн уурын зуухны шинэчлэл хийх
6. Хүүхэд бүрийн авьяасыг хөгжүүлэх боломж бүрдүүлэн, 20 нэр төрлийн хичээлээр анги нийтийн олимпиад зохион байгуулах
7. Тэс, Наранбулаг, Зүүнговь сумын соёлын төвийн, Улаангомд ардын язгуур урлагийн төвийн барилгыг ашиглалтанд оруулж, Улаангомд баруун монголын уламжлалт соёлын төвийн барилгын ажлыг эхлүүлэн, Бөхмөрөн сумын соёлын төвийн барилгын зураг төсөв хийлгэх
8. Сумдын Орон нутаг судлах танхимыг тохижуулах, үзмэрийн тоог нэмэгдүүлэх, сэргээн засварлах ажлыг хийх
9. Аймгийн Засаг даргын нэрэмжит “Авьяас-2013” хүүхдийн уралдаан, Баруун бүсийн хүүхдийн чуулган, язгуур урлагийн наадам зохион байгуулж, хүүхдэд ээлтэй сум, баг шалгаруулах
10. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн ажлыг эрчимжүүлэн, бүтэн өнчин хүүхдүүдэд дэмжлэг үзүүлэх
11. Хүүхэд залуучуудын паркийн барилгыг ашиглалтанд оруулж, хүүхдийн ордны барилгын зураг төсөв хийлгэх
12. Улаангом коллежийн дотуур байрны засвар хийх
13. Баруун монголын уламжлалт соёлын төвийн барилгын ажлыг үргэлжлүүлж ардын язгуур урлагийн төвийн барилгыг ашиглалтанд оруулна.

Дөрөв. Аюулгүй орчинтой Монгол хүн

1. Ойжуулалт 150-иас доошгүй га, ногоон хэрэмийн туслах зурвас 20 га, ойн хортны устгалыг 5800 га талбайд хийж, 10 булаг шандын эхийг тохижуулах, ундрагыг сэргээх ажлыг зохион байгуулах
2. Нэн ховор, ховор, элбэг ургамлын төлбөрийн үнэлгээ, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн хураамжийг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх
3. Увс нуур судалгааны өртөө, Сагил сумын Харигийн гол, Тэс сумын Тэсийн голд усны харуул байгуулах, Завхан, Тэс сумдын цаг уурын өртөөнд автомат станц байрлуулах
4. Аймгийн хэмжээнд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, сургалт сурталчилгаа зохион байгуулах
5. Аймгийн газар эзэмшил, өмчлөлийн байдалд хяналт үнэлгээ хийх замаар газар ашиглалтын аймгийн бодлогод шинэчлэлт хийж, хот төлөвлөлттэй уялдуулан олгодог болох
6. Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргаа байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэх
7. Улаангомд гэр хороололд телевизийн өргөн сувгийн кабель, интернетийн шугам татах
8. Улаангом политехник коллежийн ойжуулагч, цэцэрлэгжүүлэгч мэргэжлийн ангийн сургалтын түшиц баазын хүрээнд Огзомын ойг нөхөн сэргээх төслийг эхлүүлэх

9. ОХУ-ын Халимаг, Тува, Хакасс улсад ажлын айлчлал хийж, хамтын ажиллагааны гэрээ байгуулах, БНСУ, Япон улсын муж, хотуудтай харилцаа холбоо тогтоох ажлыг эхлүүлэх, БНХАУ-ын ШУӨЗО болон хөрш ОХУ-ын муж, улсуудад зохион байгуулдаг олон улсын форум, үзэсгэлэн худалдаанд бизнесийн төлөөлөгчдийг оролцуулах, ОХУ-аас модон материал нийлүүлж, дотоодын хэрэгцээг хангах ажилд дэмжлэг үзүүлэх
10. ОХУ-ын Красноярск мужид газар тариалангийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх курсад 3-аас доошгүй мэргэжилтнийг хамруулах
11. Хил орчмын бүс нутгийн иргэдийг хялбаршуулсан журмаар хил нэвтрэхэд саад болж буй бэрхшээлийг арилгах, ОХУ-д зорчих эрхээ хасуулсан иргэдийн талаар холбогдох байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх
12. Аймгийн төв, захын орчмын нутаг дэвсгэрт “Цагдаагийн иргэдэд үйлчлэх хэсэг”-ийг ажиллуулах
13. Цагдаагийн газарт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгж байгуулж, холбогдох байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах

Тав. Эрх чөлөөтэй Монгол хүн

Нийтийн алба, нийтийн үйлчилгээг тунгалаг нээлттэй болгож, хариуцлага, хяналтыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болгон мөрдүүлж, хүнд сурталгүй, авлигаас ангид төрийн үйлчилгээг хөгжүүлнэ.

1. Бүх сумдад иргэний танхим байгуулж орон нутгийн хөгжил, бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргах болон төрийн үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагууд бүхий л хэлбэрээр оролцон, үр дүнд үнэлгээ өгөх, хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх.
2. Төрийн бүх шатны албан хаагчдын үүргийг тодорхой болгож, үүргийн биелэлтийг үндэслэн хариуцлага тооцдог болгох.
3. Төрийн байгууллагууд улирал бүр үйл ажиллагаагаа иргэний нийгмийн танхимаар хэлэлцүүлэн дүгнүүлж, олон нийтэд тайлагнадаг журам гаргаж, мөрдөх.
4. Төрийн байгууллагууд иргэдийн санал хүсэлтэнд хуулиар тогтоосон хугацаанд хариу өгөөгүй тохиолдолд зөвшөөрсөнд тооцох зарчмыг нэвтрүүлэх.
5. Аймаг, сумын ИТХ-ын чадавхийг сайжруулж, НӨУЁБ-ын бие даасан үйл ажиллагааг бэхжүүлэн, орон нутгийн хэмжээний эрх зүйн зохицуулалтын цогц бодлоготой болгох.
6. Аймгийн хэмжээнд олгодог тусгай зөвшөөрлийн эрхзүйн орчинг шинэчлэх, лицензийн ашиглалтанд хяналт тавьж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.
7. Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэн, төрийн зарим чиг үүргийг ТББ, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх ажлыг бодитойгоор хэрэгжүүлэх.
8. “Нийтийн албанд хувийн болон нийтийн ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн хэрэгжилтийг зохион байгуулан, авилга, хүнд сурталтай холбоотой мэдээллийг хүлээн авах итгэлтэй утас, и-мэйл хаяг нээж ажиллуулах.
9. Улаангом сумын 6.7.9.10-р багийн цогцолбор төвийг барьж дуусган, багийн иргэдэд төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор багийн бүтцийг оновчтой болгох судалгаа хийх
10. Аймгийн ИТХ, Өлгий, Цагаанхайрхан, Бөхмөрөн, Зүүнхангай сумдын ЗДТГ-г автопаркийн шинэчлэл хийж, багийн дарга нарыг ээлж дараатай унаажуулах.
11. Нийтийн албыг төлөвшүүлэх зорилгоор удирдах албан тушаалтны манлайлал, менежментийн ур чадварыг дээшлүүлэх болон нийтийн албаны ажилтнуудыг чадавхижуулах сургалтыг тусгай график гарган зохион байгуулах, сумдын төрийн албан хаагчдыг ажлын байранд нь сургах ажлыг зохион байгуулах.
12. Бөхмөрөн, Давст, Завхан, Зүүнговь, Малчин, Өлгий, Сагил, Түргэн, Ховд, Хяргас, Цагаанхайрхан сумдын ЗДТГ-г хууль эрхзүйн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй болгох.
13. Зүүнговь сумын Нутгийн захиргааны ордонг ашиглалтанд оруулж, Бөхмөрөн, Тэс, Зүүнхангай сумдын Нутгийн захиргааны ордон болон аймгийн Засаг даргын Тамгын газрын барилгын өргөтгөлийн ажлыг эхлүүлэх.
14. Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудад мэдээлэл технологийн “Удирдлагын цогц систем” нэвтрүүлж, 5 сумыг интернет үйлчилгээний тоног төхөөрөмжөөр хангах.
15. Аймгийн ЗДТГ-г “Иргэдэд үйлчлэх нийтийн үйлчилгээний төв” байгуулах, зар мэдээллийн цахим самбар ажиллуулан иргэдийг мэдээллээр хангах
16. Аймгийн ЗДТГ-ын хурлын танхимыг сургалт семинарын зориулалт бүхий ханын өргөн дэлгэцийн телевиз, ухаалаг самбар болон бусад тоног төхөөрөмжөөр тохижуулах.
17. Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын офицер, ахлагчдын нийгмийн хамгааллыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

18. Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг эмнэлгийн байгууллагатай хамтарч урьдчлан сэргийлэх үзлэгт хамруулж онош тодруулах, эмчлэн эрүүлжүүлэх замаар эх орноо хамгаалах, хуулиар хүлээсэн иргэний үүргээ биелүүлэх нөхцлийг бүрдүүлэх.
19. Дайчилгааны бэлтгэл нөөцийн цэргийн нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг зохион байгуулах.
20. Гамшгийн бэлэн байдлыг хангахад цас зайлуулах хүнд механизм, тоног төхөөрөмжөөр хангах.
21. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим REAL программыг нэвтрүүлэн, архивын нэгжийг цахимжуулан улсын нэгдсэн сүлжээнд холбох бэлтгэл ажлыг хангах.
22. Архивын тасгийн техник тоног төхөөрөмжийн хангалтыг шинэчилж, шинэ байртай болох асуудлыг судлан шийдвэрлүүлэх.
23. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны харьяа цагдан хорих байр шинээр барих

Сайн үйлс дэлгэрэх болтугай.